

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ

Ч.Батцэцэг (Ph.D) *

***Abstract:** The discourse to implement economic mega projects as the Grassland Road initiated by Mongolia, Silk Road Economic Belt or One Belt and One Road, and the Chine-Russia-Mongolia economic corridor of China, and the Trans-Euroasian Railway of Russia and to tie up with development policies of the countries has been recently raised. Along with the implementation of such mega projects and construction of economic infra-structure, tourism collaboration and cultural and humanity relationship would be definitely activated and flourished in-between the neighbor countries.*

Tourism is the most rapidly developing field in the world. It is important to develop tourism between Mongolia, China and Russia that would enhance their previous regional collaboration and result in efficiency of ongoing activities. In order to develop tourism in Mongolia, it is necessary to build transportation and infrastructure that can be implemented within the projects under discussion of the three countries. The intensification of tourism would not only stimulate economic development of the three countries but also enhance mutual understanding and trust among them.

Keywords: *tourism, competitiveness, regional, infrastructure, build transportation*

Товч агуулга: *Монгол Улс, БНХАУ-ын хоорондын харилцаа дээд хэмжээнд хүрч иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтсноор хөгжлийн шинэ үе шат, шинэ боломж нээгдлээ. Өнөөдөр БНХАУ нь Монгол Улсын хамгийн том хөрөнгө оруулагч бөгөөд худалдааны гол түнш орон юм. Аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг түргэн хугацаанд хөгжүүлэх дөт зам болох агаад үр ашиг нь тодорхой чухал*

* ШУА-ийн ОУХХ-ийн ЭШАА, доктор (Ph.D)

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

салбар юм. Зохиогч эл өгүүлэлдээ, Монгол, Хятадын хооронд аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэн хөгжүүлэх таатай орчин нөхцлийг аль болохоор түргэн хугацаанд бүрдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх, хоёр талын жуулчдын тоог нэмэгдүүлэх, хоёр улсын бүс нутаг, орон нутгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг идэвхжүүлэх, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлыг зохистой шийдвэрлэх талаар өгүүлнэ.

***Түлхүүр үг:** Аялал жуулчлал, өрсөлдөх чадвар, бүс нутаг, зам харилцаа, бүтээн байгуулалт*

Сүүлийн жилүүдэд Монгол Улс, БНХАУ-ын бүх талын харилцаа эрчимтэй хөгжиж, стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаатай боллоо. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг иж бүрэн түншлэлийн харилцаа болгон хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалд, талууд эдийн засгийн хамтын ажиллагаагаа хоёр улс, ард түмний сайн сайхны төлөө чиглүүлэн идэвхтэй хамтран ажиллахаар тогтсон билээ. Улмаар Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой болохыг Монголын тал тэмдэглэсэн. Харин Хятадын тал цаашид ч харилцан ашигтай байх зарчмаар Монгол Улстай хамтран ажиллаж, хөгжлийн үр шимийг Монгол Улстай хуваалцаж, хамтын хөгжилд хүрэхийг хүсч байгаагаа онцолжээ. Чингэснээр Монгол, Хятад хоёр орны стратегийн хөгжил, хамтын ажиллагаанд гадаад дотоодын шинэ хүчин зүйл үүсэхийн сацуу шинээр маш олон боломж бий болж байна. Үүний сацуу Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын тэргүүн нарын уулзалт тогтмолжиж, гурван талыг харилцан итгэлцэх, харилцан ашигтай хамтран ажиллахад түлхэц болж байна. Иймд хөршүүдтэйгээ хамтдаа хөгжиж, хамтдаа хожих гэсэн Хятадын санаачлага, “Нэг бүслүүр, нэг-зам”, “Монгол, Хятад, Орос гурван улсын коридор” зэрэг эдийн засгийн томоохон төслүүдийг Монгол Улсынхаа “Талын зам” хөтөлбөртэй уялдуулан, хөгжлийн бодлогоо оновчтой хэрэгжүүлэх асуудал манай улсын өмнө тулгарч байна. Дээрхи томоохон төслүүдийн хэрэгжилт, бүтээн байгуулалтыг дагалдан хөрш орнуудын хооронд аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа, соёл, хүмүүнлэгийн харилцаа, идэвхжих нь ойлгомжтой.

Аялал жуулчлал нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг юм. Аялал жуулчлалын хамтын ажиллагаа нь Монгол, Хятад, Орос гурван улсын бүс нутгийн хамтын ажиллагааны нэгэн шинэ хэсэг болж байна. Аялал жуулчлалын салбар нь бусад салбарын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс илүү хялбар, сайжруулан хөгжүүлэхэд хамгийн энгийн бөгөөд нэн хурдан үр дүнд хүргэх салбар юм. Ялангуяа Монгол, Хятадын хооронд аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлснээр хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг улам боловсронгуй болгож төгөлдөржүүлэхэд чухал хүчин зүйл болохын зэрэгцээ хөгжлийг урагшлуулах дөт зам болно. Өнөөдөр аялал жуулчлал бол дэлхийн хэмжээнд хамгийн хурдацтай өсч буй салбар юм. Дэлхийн аль ч оронд гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь эдийн засаг, нийгэм, улс төрийн чухал ач холбогдолтой байдаг. Аялал жуулчлалыг “ардын дипломат” ч хэмээн нэрлэдэг. Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын (World Tourism Organization) “UNWTO World Tourism Barometer-2015”-ын судалгаанаас үзвэл, хэдийгээр эдийн засгийн хямралтай байсан ч 2015 онд аялсан олон улсын жуулчдын тоо 1,184 сая хүн болж, өмнөх оны сүүлийн үзүүлэлттэй харьцуулахад 4,4%-иар өссөн буюу 2014 оныхоос 50 сая хүнээр илүү байна. Дээрх байгууллагын урьдчилан таамагласнаар, 2016 онд дэлхийн даяар жуулчлагсдын тоо 4%-иар өсөх төлөвтэй байгаа нь өмнөх хоёр жилийг бодвол нааштай боловч өмнөх хоёр жилийн үзүүлэлтээс арай буурах хандлага ажиглагдаж байна¹ гэж дүгнэжээ. Жуулчдын тоог бүс нутгаар авч үзвэл, Ази-Номхон далайн бүсэд (+5%) аялсан олон улсын жуулчдын тоо 13 саяар нэмэгдэж, 277 сад хүрчээ. Үүнээс Зүүн хойд Ази (+5) болон Өмнөд Ази, Зүүн хойд Азийн жуулчдын өсөлт 4%-иар өсчээ. Жуулчдыг тэргүүлэх зах зээлийн орноор авч үзвэл, БНХАУ, ОХУ, Бразил, БНСУ, АНУ, Япон эхний байруудыг эзэлж байна. Сүүлийн үед ийнхүү дэлхийн аялал жуулчлалын урсгал Ази-Номхон далайн бүс нутаг, Зүүн хойд Ази руу чиглэж буй нь Монгол Улсад ашигтай чиг хандлага болж байгаа юм.

1. <http://media.unwto.org/ru/press-release/2016-01-19/>

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

Нэг. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага

Монгол Улсад гадаадын аялал жуулчлал хөгжих эхлэл тавигдснаас хойш эдүгээ нэгэн жарныг туулж байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь аливаа улс оронд ашигтай, эдийн засгийн чухал салбар гэдэг нь нэгэнт батлагдаж, орчин үеийн шинжлэх ухааны салбар болтлоо хөгжжээ.

Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.2.1.5-д аялал жуулчлалыг 2007-2021 он хүртэл хөгжүүлэх бодлогыг томъёолсон. Уг бодлогын хүрээнд аялал жуулчлалд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэн аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх замаар 2015 он гэхэд гадаадын жуулчны тоог 1 саяд хүргэхээр заасан байна. Улмаар 2016-2021 оны хооронд аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэж сайжруулах замаар Монгол Улсад ирэх жуулчдын тоог хүн амын тоотой тэнцэхүйц болгох зорилтыг дэвшүүлжээ.² Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 83-р тогтоолоор аялал жуулчлалын салбарыг үндэсний эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгон тодорхойлсон байна.

Монгол Улс гадаадаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор дэлхийн томоохон аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг, арга хэмжээнд тогтмол оролцож ирлээ. Тухайлбал, жил бүрийн 11-р сард зохион байгуулдаг “WTM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Японд 9-р сард тогтмол зохион байгуулагддаг “JATA” аялал жуулчлалын үзэсгэлэнд тус тус тогтмол оролцдог. Мөн 2014 оны 10-р сард Сингапурт 7 дахь жилдээ зохион байгуулагдсан “ITB Asia” үзэсгэлэн яармагт Монгол Улс анх удаа оролцжээ.³

ХБНГУ-ын нийслэл Берлин хотод зохион байгуулагддаг “ITB Berlin” үзэсгэлэн яармагт 1999 оноос хойш албан ёсоор оролцож байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 204-р тогтоолоор 2011

2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. Эмхтгэл УБ., 2008 он

3. www.mfa.gov.mn <http://politics.news.mn/content/193987.shtml>

онд “Соёлын түнш” орноор амжилттай оролцсон. Харин 2015 оны 3-р сард “ITB Berlin-2015” олон улсын үзэсгэлэн яармагт Монгол Улс анх удаа албан ёсны түнш орноор “Mongolia Nomadic by Nature” гэсэн аялал жуулчлалын нэгдсэн уриан дор маш амжилттай оролцлоо. Жил бүрийн “ITB Berlin” үзэсгэлэнгийн дараа аялал жуулчлалын шинэ шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч, шинэ зах зээлүүд нээгдэж байдаг ажээ. Ялангуяа энэ удаа хамгийн олон орон, дэлхийн 186 орныг төлөөлсөн 1096 аж ахуйн нэгж уг үзэсгэлэнд оролцсон юм. Монгол Улс ийнхүү анх удаа түнш орноор амжилттай оролцсоны үр дүнд 40-өөс доош насны 150 мянга гаруй залуус Монголыг зорихоор сонгосоны ихэнхи нь германчууд байв. Энэ удаагийн гадаад сурталчилгаа төр засгийн дэмжлэгтэйгээр сайтар хийгдсэн учраас Монголыг зорин ирэх жуулчдын тоо ийнхүү өсөхөөр болсон юм. Ер нь Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тооцоолсноор түнш орноор оролцсон улсад ирэх жилд нь аялах жуулчдын тоо дунджаар 8-20 хувиар өсдөг⁴ гэсэн мэдээлэл бий. Үүний үр дүнд манай улсын өмнө гадаадын зочид төлөөлөгч, жуулчдыг хүлээн авах бэлтгэлийг хангах цогц арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх, зочин хүлээн авах үйлчилгээний чиглэлээр олон төрлийн ажлыг хэрэгжүүлэх зорилго тавьсан. Чингээд Аялал жуулчлалын тухай хууль, Үндэсний хөтөлбөрөө даруй батлуулах шаардлагатай болсон юм. Энэхүү хууль эрх зүйн зохицуулалтаас гадна гадаадын жуулчдад ээлтэй хандах, монгол хүний зочломтгой найрсаг сайхан сэтгэлээр угтаж, үдэх хандлагыг ард иргэдийнхээ дунд хэвшүүлэх ажлыг сайтар хийх ёстой.

Өнөөдрийн байдлаар, Монгол Улсын аялал жуулчлалын салбар эдүгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 5,3 хувийг бүрдүүлж, сүүлийн жилүүдэд дунджаар 450 мянга орчим жуулчин хүлээн авч байна. Ази Номхон далайн 25 орноос 19-д жагсаж байна. Гэвч Дэлхийн эдийн засгийн форумын 2014-2015 оны дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Монгол Улс 3.82 оноогоор дэлхийн 140 орноос 98-д бичигджээ. Уг тайланд Монгол Улс 11.5 тэрбум ам долларын ДНБ-тэйгээс 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3971.86 ам доллар хэмээн тооцсон байна. Дэлхийн эдийн засгийн форумын төвөөс 2015 оны

4. <http://zasag.mn/m/megd/view/8895>

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

“Аялал жуулчлалын салбар дахь өрсөлдөх чадвар индекс-15”-ийг нийтлүүлжээ. Энэ төв дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлтийг жил бүр гаргадаг. Уг индексээр Монгол Улс аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индексийн 7 онооны үзүүлэлтээс 3.3 оноо авч, 141 улсаас 99-д бичигдсэн. Ингэснээр Монгол Улс аялал жуулчлалд бэлэн бус эдийн засагтай улс орнуудын 42-т бичигдэж, бизнесийн орчин, дэд бүтцийн үзүүлэлтээр тааруу үнэлгээтэй гарсан байна.⁵

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалыг үндэсний тэргүүлэх салбарын хэмжээнд тавьж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлж, 2020 он гэхэд өрсөлдөх чадварын үзүүлэлтийг 80-д хүргэх, дотоодын нийт бүтээгдэхүүний 14 орчим хувийг бүрдүүлэх тодорхой зорилт тавин ажиллаж байна. Уг зорилтын хүрээнд Монгол Улсад аялал жуулчлалын бүс нутгуудыг бий болгож, гадаад дотоодын жуулчид аятай тухтай жуулчлан амрах иж бүрэн дэд бүтэц, үйлчилгээний менежментийг болон олон улсын түвшинд ойртсон жуулчны онгон цэвэр байгаль, нүүдэлчин ёс заншил, уламжлалт соёл дээр тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгож, Монгол орныг аялал жуулчлалын онцгой голлох орнуудын нэг болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна. Тухайлбал, Монгол Улсын “Ногоон хөгжлийн бодлого”-ыг батлуулан, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газрын 2015 оны 06 сарын 29-ний өдрийн хуралдаанаар батлуулжээ. “Аялал жуулчлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Тогтвортой аялал жуулчлалын төлөвлөгөө”, “Тусгай сонирхлын аялал жуулчлалын төлөвлөгөө”-г тус тус боловсруулжээ.⁶ Мөн Казиногийн тухай хуулийг УИХ-д, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийг Засгийн газарт тус тус өргөн барьжээ. Монгол Улсын Байгал орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яамнаас (БОНХАЖ) мэдээлснээр, дэлхийн жуулчдыг Монголд аялах нөхцлийг хангахын тулд дараах ажлуудыг төлөвлөөд хэрэгжүүлж эхэлсэн юм. Тухайлбал, 2014 оны байдлаар, Бангкок, Берлин, Бээжин, Истанбул, Парис, Москва, Сингапур, Сөүл,

5. www.touristinfocenter.mn/news_more.aspx?CatelD=0&NewsLD=2056

6. <http://zasag.mn/m/megd/view/8895>

Токио, Хонконг зэрэг олон улсын 10 гаруй чиглэлд түүнчлэн бусад захиалгат болон тусгай үүргийн нислэгийг үйлдэж байна. Монгол Улсад жилд 3-5 сая зорчигч хүлээн авах хүчин чадал бүхий Олон улсын онгоцны буудлыг 2017 онд ашиглалтад оруулна. Жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2014 онд дэлхийн 42 улс орноос ирэх жуулчдыг Монгол Улсад визгүй зорчих нөхцлийг бүрдүүлснээр нийт 60 улсын иргэн визгүй зорчих эрхтэй болов. Мөн ОХУ-тай иргэд харилцан визгүй зорчих гэрээг байгуулжээ. Ийнхүү ОХУ, Монгол Улсын иргэд хоорондоо визгүй зорчих болсны үр дүнд аялал жуулчлалын салбар сэргэж, монголчууд Байгаль нуурыг үзэх, Итгэлт Хамбад мөргөх аялал хийхийн зэрэгцээ худалдаа, наймаа эрхлэхээр ОХУ-ын БНБУ-ыг зорих болсноор хилийн боомтуудын ачаалал эрс нэмэгдэж, Монголын зах зээлд хойд хөршийн бараа бүтээгдэхүүн мэдэгдэхүйц элбэгшиж, монголчуудын хамгийн их очдог, байнга оршин суудаг хотоор Улаан-Үд тодорчээ.

Нөгөөтэйгүүр Монгол Улсад аялах бүлэг жуулчны виз авах үйл явцыг хөнгөвчлөх, хилийн боомтуудаар жуулчид нэвтрэх журмыг боловсронгуй болгох, голлох зах зээлийн орнуудын жуулчны визийг хөнгөвчлөх эрх зүйн орчин бүрдүүлэх, E-Visa үйлчилгээг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлж, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын СТЕП сангаас “Аялал жуулчлалын салбарын ажиллагсад, хөтөч тайлбарлагч нарын чадавхийг сайжруулах, сургагч багш нарыг бэлтгэх” төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу 2030 оны хөгжлийн чиг хандлагад тусгаснаар нийслэл хотыг Зүүн хойд Азийн бизнес аялал жуулчлалын зангилаа, Монгол туургатны соёлын аялал жуулчлалын төв, 2020 онд 2 сая, 2030 онд гадаадын 5 сая жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, соёлын олон талт үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэх зорилгоор “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг 2014 оны 9-р сарын 22-ний өдөр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан юм.⁷

Мөн түүнчлэн 2015 оны наймдугаар сард Зүүн хойд Азийн аялал жуулчлалын 11 дэх удаагийн олон улсын форум (IFNAT)-ыг

7. www.Assa.mn 2015.03.06

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

Улаанбаатар хотод зохион байгуулав. MICE tourism буюу “Хурал зөвлөгөөн, үзэсгэлэн яармагийн аялал жуулчлал” сэдвийн дор зохион байгуулагддаг эл арга хэмжээнд БНХАУ, ОХУ, Япон, БНСУ зэрэг орны мэргэжлийн төлөөлөгчид оролцохоос гадна Монголын төлөөлөгчид оролцов. Монгол Улс 2008 онд энэ форумыг Улаанбаатар хотод зохион байгуулснаас хойш жил бүр идэвхтэй оролцож ирсэн. Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг эдгээр арга хэмжээ нь бүс нутгийн аялал жуулчлалын салбарт тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг хэлэлцэж, тэдгээрийг даван туулах гарцыг хамтран боловсруулах, аялал жуулчлалын салбарт бүс нутгийнхаа улс орнуудтай харилцах харилцаагаа улам бататгах, туршлага, мэдээлэл солилцох зэрэг олон талын ач холбогдолтой.

Дотоодын аялал жуулчлалын тухайд. Монголын аялал жуулчлалын салбарт орхигдуулж үл болох томоохон хэсэг бол дотооддын аялал жуулчлал юм. Өнөөдөр дотоодын аялал жуулчлалаа (inbound) гадагшаа чиглэсэн аялалтайгаа (outbound) эн тэнцүү авч явах шаардлага бий болж байна. Монгол Улс гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо жил бүр тодорхой хэмжээний арга хэмжээ авч, олон төрлийн ажил санаачлан зохион байгуулж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас “Монголд зочлох жил”, “Монголыг нээх жил”, “Их Монгол улс байгуулагдсны 800 жилийн ойн жил”, “Монгол наадам”, “Дээлтэй Монгол,” Мөсний баяр, Тэмээний баяр, Өгий нуурын мөсний баяр, Ганга нуурын чуулган, Дөрвөн түмэн тэмээний баяр, Сарлагийн баяр, Эсгийн баяр, Бүргэдийн баяр, Орхоны хөндийн 99 баатар, Адуучин, Айс Чэллэнж Монголиа гм. Үүнээс гадна аялал жуулчлалтай холбоотой үзэсгэлэн яармагуудыг дотооддоо зохион байгуулж ирэв. “АЙ ТИ ЭМ 2015” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “ХОРЕКА 2015” зочлох үйлчилгээний үзэсгэлэн, “Үндэсний аялал жуулчлалын Улаанбаатар 2015” үзэсгэлэн тус тус зохион байгуулж, аймгийн төлөөлөгчид, аж ахуйн нэгжүүд олноороо оролцсон байна. Дотоодод зохион байгуулдаг үзэсгэлэн яармагт БНХАУ-аас ӨМӨЗО, ОХУ-аас БНБУ-ын төлөөлөгчид, аж ахуйн нэгжүүд тогтмол оролцдог юм. Эдгээр арга хэмжээ нь зах зээлийн голлох орнуудаас Монгол Улсад ирж буй жуулчдыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлдэг. Нөгөөтэйгүүр Монгол Улс

хөрш орнуудынхаа хил залгаа бүс нутагт жил бүр зохион байгуулагддаг гурван улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг, фестиваль наадамд тогтмол оролцож ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Хоёр. Монгол-Хятадын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа, онцлог байдал

Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт: Талууд аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, хоёр улсын ард түмэн аялал жуулчлалаар дамжуулан бие биеийнхээ эдийн засаг, соёл, байгалийн үзэмж, түүхийн дурсгалт газрууд болон үндэсний уламжлалыг харилцан таньж мэдэх явдлыг хөхиүлэн дэмжиж, хоёр улсын аялал жуулчлалын салбар, байгууллага хооронд хамтын ажиллагаа тогтоох явдлыг дэмжин, нөгөө талдаа зохиогдох аялал жуулчлалыг сурталчилсан арга хэмжээнд шаардлагатай туслалцаа үзүүлэн хоёр улсын иргэд харилцан зорчих явдлыг урагшлуулах; талууд аялал жуулчлалын салбарт харилцан хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, хоёр улсын хооронд аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг, шаардлагатай хөнгөлөлтийг үзүүлэх тухай заасан.⁸ БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр Монгол Улсын ССАЖЯ, БНХАУ-ын Соёлын яам хоорондын соёлын солилцооны протоколд гарын үсэг зурсан юм.

Аялал жуулчлалын хамтын ажиллагааны хөгжил нь хоёр улсын хөрөнгө оруулалт бизнесийн үйл ажиллагааг дэмжих болно. Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалд: талууд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нөөц боломжийг ашиглан, худалдааг хөнгөвчлөх бодлогыг дэмжих, Зүүн хойд Азийн үзэсгэлэн яармаг, Монгол, Хятад, Оросын худалдаа, эдийн засгийн чуулга уулзалт, Монгол, Хятадын үзэсгэлэн яармаг зохион байгуулах зэрэг замаар хоёр улсын худалдааны хэмжээг жилээс жилд нэмэгдүүлэх, 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүргэхийг зорино. Талууд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний

8. “Өнөөдөр” сонин. 2013-10-26

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

хоёр талын худалдаа дахь хувийг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжих тухай дээрх заалтыг оруулсан нь уг салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад төрийн албан ёсоор айлчлахын өмнө Хятадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, сэтгүүлчидтэй Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж уулзаж, сэтгүүлчдийн асуултанд хариулт өгөв. Тухайлбал, - Монголын аялал жуулчлалын талаар, Монгол Улс гадаадын жуулчдыг илүү татах ямар бодлого явуулж байна вэ?” гэсэн асуултанд: –“Аялал жуулчлал бол Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой чухал салбарын нэг юм. БНХАУ-ын иргэд бол дэлхий дээр хамгийн их, олон тоогоор аялдаг хүмүүс. Энэ чиглэлд байгаа боломжийг ашиглаж, улам өргөтгөж ажиллаасай гэж би боддог. Далайд гарцгүй орны хувьд мэдээж агаарын харилцаа маш чухал. Энэ чиглэлд агаарын харилцаагаа хөгжүүлэх талаар идэвхитэй ажиллаж байгаа. Мөн БНХАУ-тай ч гэсэн гэрээ хэлцэл байгуулан ажиллаж байна. Монголын ард түмний ёс заншлыг хүндэтгэдэг, Монголын байгалийн сайхныг үзэх, Монголын ард түмний ёс заншлын өвөрмөц байдлыг үзэх гэсэн хүн бүхэнд Монгол Улс нээлттэй гэдгийг энд хэлье”⁹ гэж хариулав.

Өнөөдөр хятад иргэд дэлхий дээр хамгийн их аялах дуртай хүмүүсийн тоонд багтах аас гадна БНХАУ дэлхийн аялал жуулчлалын салбарын тэргүүн эгнээнд явж байна. БНХАУ-ын Аялал жуулчлалын академиас жил тутам эрхлэн гаргадаг тайлангаас харахад, 2009 онд 47 сая хүн тус улсаас гадаадад аялж, 2010 онд энэ тоо 54 сая, 2020 онд 100 саяд хүрэх төлөв тооцоо гаргажээ. Тэгвэл 2014 оны статистикийн тооцоогоор, Хятадаас гадаадад аялагчдын нийт тоо 11 саяар өсч, 109 саяд хүрчээ. 2014 оны эхний гурван улиралд жуулчдын зардал 17%-иар өссөн нь мэдэгдэхүйц үр дүн боловч өмнөх жилүүдтэй харьцуулахад (2012 онд 40%, 2013 онд 26%) буурсан байна. БНХАУ 2012 оноос гадаадад зорчих жуулчдын хамгийн том зах зээлтэй болж, нийт зардал 2013 онд 129 тэрбум ам долларт хүрчээ.¹⁰ Дэлхийн улс орон ч хятадын жуулчдыг татахын тулд визийн нөхцлийг хөнгөвчилж байна. Тухайлбал, Хятад, Канад 2014 оны 3 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн

9. <http://www.mglradio.com/main/mongoliannews/1044943>

10. <http://media.unwto.org/node/42730>

харилцан 10 жил хүртэлх хугацааны олон удаа орох ангиллын виз олгох болсон талаар БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И мэдэгдсэн байна. Мөн Хятад, Америкийн хооронд харилцан 5-10 жилийн виз олгох журмыг 2014 оноос хэрэгжүүлж байна. 2013 онд Хятадын 1,8 сая жуулчин АНУ-д аялж, 21 тэрбум ам долларын эдийн засгийн үр ашиг өгч, 100 мянга гаруй ажлын байрыг шинээр бий болгосон бөгөөд 10 жилийн виз олгосноор энэ тоог 2 дахин нэмэгдүүлэхээр тооцоолсон гэж АНУ-ын албаны хүмүүс мэдээлсэн байна. Үүний зэрэгцээ 2014 онд 230 мянган Канад иргэнд Хятадын виз олгосноос 80 хувь нь бизнес, аялал жуулчлал, гэр бүлийн жуулчид байсан гэж Канадад суугаа БНХАУ-ын консул Гао Пин мэдээлжээ.¹¹

Дэлхийн эдийн засгийн форумын 2014-2015 оны дэлхийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр, БНХАУ аялал жуулчлалын өрсөлдөх чадвараар 17-рт бичигдсэн байна.¹² Ийнхүү сүүлийн жилүүдэд Хятад, Орос болон Бразил тэдгээрийн шилжилтийн эдийн засгаас гадаадад зорчих аялал жуулчлалын эрчимтэй хөгжлийн чухал хүчин зүйл болжээ. 2013 он гэхэд энэ гурван орныг чиглэсэн зах зээл нь олон улсын аялал жуулчлалын зардал нийт 81 тэрбум ам доллараар өссөний ойролцоогоор 40 тэрбум ам долларыг хангасан байна. Хятад нь 2012 онд 102 тэрбум ам долларын зардалтайгаар гадаадад зорчих аялал жуулчлалын томоохон зах зээл болж, зардлын 26%-иар өссөн үзүүлэлттэй байсан бол 2014 онд бүхэлдээ 129 тэрбум ам долларт хүрчээ. Харин ОХУ 2013 онд 25 хувийн өсөлттэй, 54 тэрбум хүртэлх ам доллартай болж, гадаадад зорчих аялал жуулчлалын дөрөвдэх томоохон зах зээл болсон байна.¹³

БНХАУ манай орныг хятадын жуулчид өөрийн зардлаар жуулчлах орны жагсаалтанд оруулж, Хятадаас бүлэг жуулчдыг хүлээн авах эрхтэй болсноор энэ салбарын хамтын ажиллагааны хөгжилд түлхэц болсон юм. Манай улсад ирж байгаа жуулчдын дийлэнхийг буюу 92 хувийг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, Австрали зэрэг 10-аад орны жуулчид бүрдүүлдэг. Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын жуулчдыг улс орон, бүс нутгаар нь ангилан үзэхэд, БНСУ-ын жуулчид 22%, БНХАУ 17%, ОХУ 17%, АНУ болон Канадын жуулчид 6% ийг

11. Эх сурвалж: Синьхуа агентлаг.

12. www.touristinfocenter.mn/news_more.aspx?CatelD=0&NewsID=2056

13. http://media.unwto.org/ru/press_release/2014-05-14/

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

тус тус эзэлж байна.¹⁴ 2016 оны 3 дугаар сард Хятадын “China Daily” сонин хятадуудын жуулчлах дуртай 10 газрыг тодруулсны дотор манай улсаас Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг багтаан нэрлэсэн байна. Сүүлийн жилүүдэд Монгол, Хятадын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа гол төлөв хоёр орны хил орчмын бүс нутгийн хэмжээнд өргөн дэлгэр явж ирлээ. Бүс нутгийн харилцаа нь улс төрийн гэхээсээ илүүтэй эдийн засаг, худалдаа, аялал жуулчлал, соёл хүмүүнлэгийн хүчин зүйлд тулгуурладаг хөрш орнуудын хөгжлийн чухал зүй тогтол, үйл явц юм. Манай хоёр орны бүс нутгийн аялал жуулчлалын хамтын ажиллагаанд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг газарзүйн байршлаараа чухалд тооцогдон идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Гэтэл БНХАУ-тай хил залгаа манай орны бүс нутгийн дэд бүтэц харьцангуй сайжирч буй ч хараахан шийдвэрлэгдээгүй асуудал байсаар байна. Тухайлбал, зайлшгүй шаардлагатай төмөрзам, автозам дутагдалтай, зарим газраа шороон замтай, эрчим хүч цахилгаан, усны хомсдолтой байдаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учруулж жуулчдын тав тухыг ихээхэн алдагдуулдаг тал бий. Нөгөөтэйгүүр манай улсад хятадын жуулчдыг хүлээн авахад хүндрэл бэрхшээлтэй асуудал бол хятадын жуулчдын визийн асуудал, хятад жуулчдын аяллын онцлог, тэдгээрийн хүсэлт, интернетийн орчин сүлжээ түүнийг хэрхэн ашиглах, хятад хэлний дээд зэргийн мэдлэгтэй хөтөч тайлбарлагчийн дутагдалтай байдлаас гадна хятад хэл гадарладаг жолооч, тогооч нарыг сургах асуудал байдгийг хятадаас жуулчид хүлээж авдаг, хятад руу монгол жуулчид аялуулдаг манай аялал жуулчлалын компаниуд хүлээн зөвшөөрдөг.

Нөгөөтэйгүүр Монгол, Хятадын хооронд аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд юуны өмнө хоёр талын итгэлцлийг бэхжүүлэх хэрэгтэй. Дэлхийн аль ч улс оронд аялахад жуулчдын аюулгүй байдлын асуудлыг онцгойлон авч үздэг ба жуулчдад тохиолдох эрсдэлтэй алхмаас урьдчилан сэргийлдэг. Тэгвэл Дэлхийн эдийн засгийн форумын 2014-2015 оны дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийн Монгол Улс жуулчидтай холбоотой гэмт хэргийн гаралт, зочид буудал, аялал жуулчлалын салбарын хөгжил зэрэг үзүүлэлтийг харгалзан авч үзвэл, зочломтгой бус буюу жуулчдад

14. <https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/samplesurvey/touristforeign.pdf>.

ээлгүй 10 улсын 10-рт буюу 141 орноос 131-т¹⁵ бичигджээ. Үүний нэг жишээ бол Бурхан Халдун ууланд аялж байсан БНХАУ-ын иргэд, өвөр монголчуудад ёс бусаар хандсан зарим иргэний зохисгүй үйлдэл юм. Иймэрхүү үйлдэл нь гадаадын жуулчдыг ялангуяа Хятадаас Монголд ирэх жуулчдад сөргөөр нөлөөлөх болно. Тэгвэл Өвөр Монголын Ордост байдаг Чингисийн онгоны цогцолборыг үзэхээр дэлхийн олон мянган жуулчин зорьсоор байна. Мөн “Хятадаас ирэх жуулчдын тоо нэмэгдвэл үндэсний аюулгүй байдалд харшилна” гэсэн хуучинсаг үзэл баримтлал болон гадны хөрөнгө оруулагч хийгээд жуулчдад “харийн хүн” хэмээсэн хэт үндсэрхэг үзлээр ханддаг нь аялал жуулчлалын салбар хөгжихөд том саад болж байна. Энэ үзэл бодлоосоо салж, Хятадаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Манай улс БНХАУ-ын санаачилсан “Нэг бүслүүр, нэг зам” төслийг Монголын “Талын зам” төсөлтэйгөө уялдуулах ажлыг эл салбартаа эхлүүлээд байна. Тухайлбал, БНХАУ-ын Сиан хотод “Торгоны зам”-ын эдийн засгийн бүслүүрийн дагуу байрлах улс орнуудын аялал жуулчлалын Сайд нарын анхдугаар хурал, Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Торгоны зам”-ын аялал жуулчлалын 7 дугаар хурал”-д тус тус оролцож, “Торгоны зам”-ын дагуу аялал жуулчлалын нэгдсэн зах зээлийг бий болгох талаар санал бодлоо солилцож, НҮБ-ын ДАЖБ-ын “Торгоны зам” хөтөлбөрийн “Нүүдэлчдийн замаар аялахуй” төсөлд хамтран ажиллах талаар тохиролцов. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар БОНХАЖЯ-ны дэргэд “Торгоны зам”-ын аялал жуулчлалын төслийн нэгж байгуулахыг дэмжсэн бөгөөд БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А-315 дугаар тушаалаар “Торгоны замын аялал жуулчлал” төслийн нэгжийг байгуулаад байна.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын ихэнхи нь зөвхөн дулааны аяллын чиглэл-маршруттай байдаг тул жуулчны баазууд өвлийн улиралд үйл ажиллагаагаа шууд зогсоодог, өөрөөр хэлбэл, Монголд 10 дугаар сараас 4 дүгээр сар хүртэл аялал жуулчлалын үйл ажиллагаа идэвхгүй байдаг. Монголд өвлийн улиралд жилд 80.000 орчим жуулчин ирдэг

15. www.touristinfocenter.mn/news_more.aspx?CatelD=0&NewsLD=2056.

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

гэсэн мэдээлэл бий боловч үнэн хэрэгтэй түүнээс маш цөөн хүн ирж байна. Тэгвэл манайхтай адил хүйтний улиралтай Хятадын хойд нутагт өвлийн улиралд аялал жуулчлалын үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Харбиний цас мөсний баярыг гучаад жил маш амжилттай зохион байгуулсаар иржээ. Мөн Өвөр Монголын аялал жуулчлалын улирал нь хэдийгээр манай улстай адил улирлын шинж чанартай байдаг хэдий ч зун, намрын улиралд ихээхэн ашигтай ажиллаж, гадаад, дотоодын жуулчдыг энэ хугацаанд маш ихээр хүлээн авч байна. Өвөр Монголын аялал жуулчлалын салбар Хятадын аялал жуулчлалын зах зээлд дээгүүр байр эзэлдэг бөгөөд гадаад дотоодын жуулчдыг маш ихээр хүлээж авдаг, сурталчилгааг маш сайн хийдэг. БНХАУ-ын Засгийн газраас ч соёлын бүтээн байгуулалтын бодлогын хүрээнд Өвөр Монголын болон бусад ӨЗО-ы аялал жуулчлал, үндэсний соёлын өв уламжлалыг нь хөхиүлэн дэмжих, монгол үндэстний түүхэнд холбогдох газруудыг хамгаалалтандаа авч, сэргээн хөгжүүлэхэд асар их хөрөнгө оруулалтыг хийж байгааг бид харж байна. Бидэнд хөршийнхөө туршлагаас суралцаж, орон нутгийнхаа давуу талыг түшиглэсэн аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд хил орчмын орон нутгийнхаа дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын аялал жуулчлалыг зохицуулах хурал 2015 оны 4 дүгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөххотод болж, өмнө нь энэ хурал “Монгол-БНХАУ-ын хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах хурал” нэрээр зохиогддог байсан бөгөөд энэ жилээс Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын аялал жуулчлалын уулзалт болон өргөжиж, шинээр Улаанбаатар хот, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар нэмэгджээ. Уг хурлаар Манжуур-Чита-Улаан-Үд-Эрхүү-Улаанбаатар-Ар Хашаат чиглэлд автомашины аялал явуулахаар болов. Мөн “Талын од” нэртэй жуулчны галт тэргийг Хөххот-Улаанбаатар-Улаан-Үд чиглэлд аялуулж, ӨМӨЗО, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын залуучуудын аяллыг Улаанбаатар хүртэл өргөжүүлэн явуулж, гурван улсын санаачилгаар явагдаж байгаа “Цайны их зам” аяллын маршрутыг үргэлжлүүлэн дөрөвдөгч орны жуулчдыг татах, хамтарсан сурталчилгаа явуулах зэрэг асуудлыг

хэлэлцсэн байна.¹⁶ Энэхүү Монгол, Хятад, Оросын хооронд “Цайны их зам” төслийг анх 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэ ажлын хүрээнд 2010-2011 онд гурван улсын “Өвлийн цайны жин” туршилтын төслийг Хөххот-Эрээн-Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг-Хиагт-Улаан-Үд-Эрхүүгийн чиглэлд хэрэгжүүлж байсан. Улмаар энэ төслийг Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) стандарт хэм хэмжээнд хүргэж, зохион байгуулагчид нь “Цайны их зам” төслийг аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн болгох, Монгол, Хятад, Оросын нутаг дэвсгэрт аж төрдөг ард түмний түүх-соёлын өв уламжлал, үндэсний зан заншлыг дэлхийн түвшинд хүргэх, гурван улсын энэ замыг дэлхийн аялал жуулчлалын брэнд болгож, олон тооны жуулчдыг татахаар тохиролцсон аж. Чингээд ЮНЕСКО-ийн соёлын өвд бүртгүүлэхээр Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын холбогдох төрийн байгууллагын төлөөлөгчид Санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулжээ. 2016 оны 3 дугаар сард Монгол Улс, ОХУ, БНХАУ дэлхийн хамгийн урт, хил дамнасан аялал жуулчлалын “Цайны их зам” аяллын маршрутыг бий болгох зорилготойгоор Аялал, жуулчлалын холбоонд нэгдлээ. “Цайны их зам” төслийн аялал, жуулчлалын дэд бүтцийн хөгжлийн асуудлаарх эдийн засгийн форумын хүрээнд Оросын зургаан бүс нутаг Аялал, жуулчлалын холбоонд нэгдэх төлөвлөгөөний тухай Протоколд гарын үсэг зурсан байна.¹⁷

Нөгөөтэйгүүр манай улсаас Хятадад зохиогддог аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг, холбогдох хурал семинар, бизнес чуулганд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг компаниуд тогтмол оролцож ирсэн. Монголын жуулчид Хятад руу голдуу хамт олон, гэр бүлээрээ Хонгконг, Макао, Хайннань, Гуанжоу, Шэньжэн, Шанхай, Хөххот, Утай гүмбэн чиглэлд аялж жуулчилдаг. Тэгвэл Монгол, Хятадын хооронд аялал жуулчлалын шинэ шинэ хэлбэрийг бий болгож болох бөгөөд эрүүл мэндийн аялал, худалдааны аялал зохион байгуулах бүрэн боломжтой. Нөгөө талаас, Монголд ирж буй гадаадын жуулчдын дийлэнхи нь Хятадаар дамжиж ирдэг. Мөн Хятадад ирэх жуулчдын тоо жил бүр 8%-иар өсч буй энэ таатай нөхцлийг бид чадварлагаар ашиглах боломжтойгоос гадна Хятадын аялал жуулчлалын зах

16. http://zaluu.com/news/index.php?url=http://uls.mn/world.html?id_33323

17. <http://www.orloo.info/> RIA Novosti.

*МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТҮЛХЭЦ БОЛОХ НЬ*

зээлд Монгол Улс хэрхэн яаж байр суурь эзлэх вэ гэдгийг бодолцох хэрэгтэй. Үүний тулд хоёр талын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, энэ зах зээл дээрх мэдээ мэдээллийг харилцан солилцох явдал онцгой чухал юм.

Орчин үед соёлын аялал жуулчлал нь аялал жуулчлалын бас нэг төрөл болж эрчимтэй хөгжиж байгаа явдал нь нэг талаар, хоёр орны хил орчмын бүс нутгийн хоорондын урлаг соёл болон аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг нээж өгч байна. Үүний тулд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэл болгох, өөрийн гэсэн аялал жуулчлалын брэндийг бий болгох талаар хэдийгээр олон жил ярьж хэлэлцэж буй ч гэсэн өдий хүртэл дорвитой алхам хийгдээгүй, Засгийн газрын дэмжлэг туслалцаа үгүйлэгдсээр байна. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд зам харилцаа, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх шаардлагатай. Үүнд, агаарын зам нээх, төмөр зам, автозам, эрчим хүч-цахилгааны асуудлыг шийдвэрлэх, улмаар зочид буудал, жуулчны бааз, үзвэр үйлчилгээ, мэргэжлийн боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх нь чухал болой.

ДҮГНЭЛТ

Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа нь олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх бөгөөд тэрхүү хамтын ажиллагаа аялал жуулчлалаар дамжуулан улс үндэстний хооронд найрсаг харилцаа бий болгохоос гадна эдийн засгийн таатай нөхцлийг бүрдүүлж, эдийн засгаа өсгөхөд маш үр ашигтай, үр өгөөжөө түргэн хугацаанд хүртэнэ. Дэлхийн улс орнууд өөрийн онцлог давуу талаа ашиглан энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэд бүтцээ хөгжүүлэх, ДНБ-ээ өсгөх, худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, санхүүжилтээ нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, ядуурлыг бууруулах, байгаль орчноо хамгаалах, нийгэм соёлын өв баялагаа бататгах, нөхөн сэргээхэд чухал ач холбогдолтой хэмээн үздэг нь практик амьдралд батлагдаж байна. Аялал жуулчлалын хөгжил нь геополитик, геоэдийн засаг, геосоёл, газар нутгийн үндэстэн ястан, соёл, шашныг нэгтгэн эдийн засгийн шинжтэй хөгжлийг агуулдаг.

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдлыг харахад, хэдийгээр харьцангуй хөгжиж, жуулчдын тоо өсч байгаа

хэдий ч БНХАУ-ын аялал жуулчлалын салбарын хөгжлөөс ихээхэн зөрүүтэй байна. Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжилд аялал жуулчлалын салбар чухал үүрэг гүйцэтгэх учраас энэ салбарыг тогтвортой, түлхүү хөгжүүлэхэд хоёр хөрштэйгээ хамтран ажиллах хэрэгтэй болж байна. Чингэхдээ өнөөдөр “Нэг бүслүүр, нэг зам”, “Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридор” төслийн хүрээнд “Талын зам”-ын төслийг хэрэгжүүлэх нь чухал юм. Ялангуяа манай хоёр хөрш орон дэлхий аялал жуулчлалын салбарт дээгүүр байр эзэлж байгаа боломжийг бид оновчтой ашиглах хэрэгтэй. Манай улсад аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулахад Хятадын хөрөнгө оруулалт, туршлага хэрэгтэй. Юуны өмнө дэд бүтцийн асуудлыг дээрх томоохон төслүүдийн хүрээнд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь чухал юм. Үүнд: агаарын замыг нээлттэй болгож, олон улсын нислэгийн компаниудын тоо, нислэгийн тоо, давтамжийг нэмэгдүүлэх, хил орчмын болон дамжин өнгөрөх аяллын бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих, жуулчин тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг ажлыг хийх шаардлагатай байна.

Өнөөдөр БНХАУ Торгоны замын эдийн засгийн бүс бол эртний Торгоны замын шинэ хөгжил, аялал жуулчлал 21 дүгээр зуунд Торгоны замыг дэмжих гол түлхүүр салбар¹⁸ хэмээн үзэж байна. Торгоны замын аялал жуулчлалыг сэргээх, хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын засгийн газраас олон улсад хандсан тодорхой тодорхой арга хэмжээ авч байгааг энд дурьдах нь зүйтэй юм. Энэ төслийн хүрээнд “Нэг бүслүүр, нэг зам” гэсэн бүтээн байгуулалтын төслийг санаачилж, олон улс болон бүс нутгийг хамруулахаар төлөвлөж, хөрш зэргэлдээ орнуудтай гадаад харилцааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт хийхийг зорьж байна. Үүнтэй уялдуулан аялалжуулчлалыг нутаг нутгийн онцлогийг харгалзан бүсчилэн хөгжүүлэх, зөвхөн зүүн аймгуудаар хязгаарлахгүй баруун аймгуудаар Баян-Өлгий-Ховд-Увс-БНХАУ-ын Синьзяны өөртөө засах орон-Казахстан-ОХУ-ын Алтайн бүгд найрамдах улс гм чиглэлээр үйл ажиллагаа явуулвал илүү үр өгөөжтэй болох буй заа. Иймд Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд эдгээр төслийн давуу тал, боломжийг ашиглаж, улс эх орныхоо эдийн засгийг урагшлуулан хөгжүүлэх таатай нөхцөл нэгэнт бүрдлээ хэмээн үзэж байна.

18. mn.chineseembassy.org/mn/xw/t1140110.htm